

Улаанхус сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн  
санхүүгийн тайлангийн аудит

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улаанхус сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн  
санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БӨА-2024/154/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="#">www.audit.mn</a>	Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ж.Айгүл
Өлгий хот	Утас: 70422954 Цахим хаяг: aigulj@audit.gov.mn
2024 он	Аудитын менежер: Х.Женисбек Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn
	Ахлах аудитор: У.Ербол Утас: 99425121 Цахим хаяг: erbolu@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

БӨА-2024/154/НА-СТА-ТШЗ

Улаанхус сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**АГУУЛГА**

---

- 1. Хараат бус аудиторын дүгнэлт .....
- 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....
- 3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
  - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....
  - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
  - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....
  - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт .....
- 4. Аудитын тайлан .....

  - 4.1 Ерөнхий зүйл .....
  - 4.2 Материаллаг байдал .....
  - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
  - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....
  - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....
  - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....

- 5. Аудитын илрүүлэлт .....
- 6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл .....

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
Аймгийн ИТХ	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал

Улаанхус сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн  
санхүүгийн тайлангийн аудит

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

Төсвийн захирагч



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,  
Утас/Факс: (976) 7042-2954  
E-mail: bayanulgi@audit.gov.mn

УЛААНХУС СУМЫН ЗДТГ-ЫН  
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ С.БОТАКӨЗ  
ТАНАА

2024.02.08 № 66  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улаанхус сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улаанхус сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

2023-оны жилийн эцсийн санхүүгийн тайлантай холбоотой онцлох асуудал гараагүй

Аудитын гол асуудал

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 994.6 сая төгрөгийн гүүр, 33.7 сая төгрөгийн инженерийн хийцтэй худаг, сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 100.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгө орлого авч данс бүртгэлд тусгасан байна.

00402037

Улаанхус сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн  
санхүүгийн тайлангийн аудит

**Бусад асуудлын хэсэг**

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ж.АЙГҮЛ



Улаанхус сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>23,563,000.00</b>	<b>23,334,601.00</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	1,500,000.00	1,291,601.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,500,000.00	1,291,601.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	22,063,000.00	22,043,000.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	12,163,000.00	12,143,000.00
35420	Аж ахуйн материал	12,163,000.00	12,143,000.00
35600	Мал амьтад	9,900,000.00	9,900,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>9,191,254,513.16</b>	<b>9,686,623,255.91</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	9,191,254,513.16	9,686,623,255.91
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	8,963,950,513.16	9,458,364,620.07
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,962,630,642.51	3,052,359,673.51
39202	Хуримтлагдсан элэгдэл	(327,980,581.66)	(401,663,741.30)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	225,001,434.00	88,798,334.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(153,231,044.96)	(39,601,350.62)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	54,777,915.00	82,661,515.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(37,468,331.58)	(41,416,931.66)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	7,955,671.00	13,466,371.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(3,072,604.05)	(4,015,104.36)
39209	Зам, гүүрийн байгууламж	5,852,808,544.00	6,847,437,384.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(89,836,408.86)	(282,893,473.98)
39214	Бусад үндсэн хөрөнгө	136,700,000.00	168,700,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(7,334,722.24)	(25,468,055.52)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	227,304,000.00	228,258,635.84
39301	Програм хангамж	10,336,400.00	11,759,639.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(536,400.00)	(1,005,003.16)
39303	Бусад биет бус хөрөнгө	217,504,000.00	217,504,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III-I+II</b>	<b>9,214,817,513.16</b>	<b>9,709,957,856.91</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>10,381,364.00</b>	-
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	10,381,364.00	-
<b>413</b>	<b>Өглөг</b>	10,381,364.00	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	5,000,000.00	-
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	5,381,364.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	5,381,364.00	-
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>9,204,436,149.16</b>	<b>9,709,957,856.91</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	9,204,436,149.16	9,709,957,856.91
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,009,407,276.32	2,009,407,276.32
51101	Өмч: - төрийн	2,009,407,276.32	2,009,407,276.32

Улаанхус сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>		
51210	Өмнөх үеийн үр дүн	5,866,481,328.99	6,372,003,036.74
51220	Тайлант үеийн үр дүн	1,322,361,915.44	5,866,481,328.99
51200	Тайлант үеийн үр дүн	4,544,119,413.55	505,521,707.75
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,328,547,543.85	1,328,547,543.85
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>9,214,817,513.16</b>	<b>9,709,957,856.91</b>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>5,314,278,269.00</b>	<b>1,588,833,466.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	-	<b>800,597,110.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	-	800,597,110.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	-	800,597,110.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>5,314,278,269.00</b>	<b>788,236,356.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	4,573,831,969.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	36,533,800.00	-
131005	Хөрөнгийн санхүүжилт	4,537,298,169.00	-
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	6,258,600.00	25,965,365.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,258,600.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	25,965,365.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	734,187,700.00	762,270,991.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	510,609,700.00	762,270,991.00
132005	Хөрөнгийн санхүүжилт / орон нутгийн төсөвт байгууллага/	223,578,000.00	
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>686,534,701.85</b>	<b>1,072,003,424.91</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>686,534,701.85</b>	<b>1,072,003,424.91</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	611,888,891.85	1,070,900,179.91
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	317,733,944.00	476,787,499.00
210101	Үндсэн цалин	317,733,944.00	361,463,245.00
210102	Нэмэгдэл	-	109,300,254.00
210104	Урамшуулал	-	6,024,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	38,588,500.00	63,819,500.00
210201	Тэтгэврийн даатгал	26,701,800.00	44,597,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,388,300.00	4,805,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,266,300.00	3,844,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	566,500.00	961,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,665,600.00	9,611,100.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	24,554,040.00	30,261,837.00
210301	Гэрэл, цахилгаан	1,785,825.00	4,057,360.00
210302	Түлш, халаалт	22,768,215.00	26,204,477.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	36,413,450.00	42,629,600.00
210401	Бичиг хэрэг	4,811,000.00	3,323,200.00
210402	Тээвэр, шатахуун	27,033,750.00	33,597,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,568,700.00	5,385,000.00

**Улаанхус сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн  
санхүүгийн тайлангийн аудит**

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	324,100.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	314,100.00	957,388.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	530,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	314,100.00	427,388.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	6,628,500.00	11,452,112.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	527,700.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	147,700.00
210604	Урсгал засвар	6,628,500.00	10,776,712.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	5,842,000.00	8,545,540.00
210702	Дотоод албан томилолт	1,842,000.00	5,023,040.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	4,000,000.00	3,522,500.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,381,300.00	77,956,190.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	262,200.00	76,591,490.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	362,200.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	90,300.00	180,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	185,700.00	411,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	75,000.00	85,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	333,600.00	512,000.00
210807	Газрын төлбөр	37,300.00	131,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	35,000.00	45,100.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	180,433,057.85	358,490,513.91
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	22,816,240.00	43,583,492.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	576,100.00	896,288.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	157,040,717.85	314,010,733.91
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	74,645,810.00	1,103,245.00
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	36,533,800.00	-
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	36,533,800.00	-
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	38,066,600.00	700,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	14,038,300.00	-
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	24,028,300.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	700,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	45,410.00	403,245.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	45,410.00	403,245.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>4,627,743,567.15</b>	<b>516,830,041.09</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	83,624,153.60	11,308,333.34
225003	Хөрөнгө оруулалтын гарз	83,624,153.60	11,308,333.34
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	(83,624,153.60)	(11,308,333.34)
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>4,544,119,413.55</b>	<b>505,521,707.75</b>

Улаанхус сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн  
санхүүгийн тайлангийн аудит

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>553,402,100.00</u></b>	<b><u>788,236,356.00</u></b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>553,402,100.00</b>	<b>788,236,356.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	36,533,800.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	36,533,800.00	
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	6,258,600.00	25,965,365.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,258,600.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		25,965,365.00
131106	Төсвийн урамшуулал		
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	510,609,700.00	762,270,991.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	510,609,700.00	762,270,991.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>526,214,310.00</u></b>	<b><u>768,145,656.00</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>526,214,310.00</b>	<b>768,145,656.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>451,568,500.00</b>	<b>767,042,411.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	312,429,400.00	481,579,100.00
210101	Үндсэн цалин	235,082,330.00	366,254,846.00
210102	Нэмэгдэл	55,587,070.00	109,300,254.00
210104	Урамшуулал		6,024,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	21,760,000.00	
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	38,588,500.00	63,819,500.00
210201	Тэтгэврийн даатгал	26,701,800.00	44,597,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,388,300.00	4,805,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,266,300.00	3,844,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	566,500.00	961,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,665,600.00	9,611,100.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	27,926,700.00	33,184,411.00
210301	Гэрэл, цахилгаан	865,000.00	4,978,185.00
210302	Түлш, халаалт	27,061,700.00	28,206,226.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	31,617,100.00	48,843,110.00

Улаанхус сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн  
санхүүгийн тайлангийн аудит

210401	Бичиг хэрэг	3,158,300.00	4,576,400.00
210402	Тээвэр, шатахуун	23,860,900.00	38,589,810.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,568,700.00	5,349,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	29,200.00	327,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	457,000.00	960,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		530,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	457,000.00	430,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	7,594,500.00	11,426,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		578,888.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		71,000.00
210604	Урсгал засвар	7,594,500.00	10,776,712.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	5,842,000.00	9,023,040.00
210702	Дотоод албан томилолт	1,842,000.00	5,023,040.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	4,000,000.00	4,000,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,369,000.00	74,471,870.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	249,900.00	72,792,370.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	362,200.00	
210803	Даатгалын үйлчилгээ	90,300.00	180,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	185,700.00	399,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	75,000.00	85,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	333,600.00	838,000.00
210807	Газрын төлбөр	37,300.00	131,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	35,000.00	45,100.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	25,744,300.00	43,734,780.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	24,827,200.00	42,318,080.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	917,100.00	1,416,700.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>74,645,810.00</b>	<b>1,103,245.00</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	36,533,800.00	-
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	36,533,800.00	
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	38,066,600.00	700,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	14,038,300.00	

Улаанхус сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	24,028,300.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		700,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	45,410.00	403,245.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	45,410.00	403,245.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>27,187,790.00</u></b>	<b><u>20,090,700.00</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>27,233,000.00</b>	<b>20,090,700.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>27,233,000.00</b>	<b>20,090,700.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	27,233,000.00	20,090,700.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	27,233,000.00	20,090,700.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>(27,233,000.00)</u></b>	<b><u>(20,090,700.00)</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	(45,210.00)	-
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	45,210.00	
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	(35,000.00)	

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,795,227,276.32	1,328,547,543.85	1,322,361,915.44		4,446,136,735.61
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>1,795,227,276.32</b>	<b>1,328,547,543.85</b>	<b>1,322,361,915.44</b>	-	4,446,136,735.61
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	214,180,000.00				214,180,000.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					-
C07	Тайлант үеийн үр дүн			4,544,119,413.55		4,544,119,413.55
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>2,009,407,276.32</b>	<b>1,328,547,543.85</b>	<b>5,866,481,328.99</b>	-	9,204,436,149.16
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	<b>2,009,407,276.32</b>	<b>1,328,547,543.85</b>	<b>5,866,481,328.99</b>	-	9,204,436,149.16
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>2,009,407,276.32</b>	<b>1,328,547,543.85</b>	<b>5,866,481,328.99</b>	-	9,204,436,149.16
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					-
D08	Тайлант үеийн үр дүн			505,521,707.75		505,521,707.75
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>2,009,407,276.32</b>	<b>1,328,547,543.85</b>	<b>6,372,003,036.74</b>	-	9,709,957,856.91

Улаанхус сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		зөрүү	хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	846,277,200.00	762,172,511.00	84,104,689.00	90.06
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	846,277,200.00	762,172,511.00	84,104,689.00	90.06
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	845,563,200.00	761,472,511.00	84,090,689.00	90.06
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	480,555,100.00	480,555,100.00	-	100.00
210101	Үндсэн цалин	368,123,900.00	366,254,846.00	1,869,054.00	99.49
210102	Нэмэгдэл	107,431,200.00	109,300,254.00	(1,869,054.00)	101.74
210104	Урамшуулал	5,000,000.00	5,000,000.00	-	100.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимт</b>	63,819,500.00	63,819,500.00	-	100.00
210201	Тэтгэврийн даатгал	44,597,200.00	44,597,200.00	-	100.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,805,600.00	4,805,600.00	-	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,844,500.00	3,844,500.00	-	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	961,100.00	961,100.00	-	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,611,100.00	9,611,100.00	-	100.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	33,308,900.00	33,184,411.00	124,489.00	99.63
210301	Гэрэл, цахилгаан	4,978,200.00	4,978,185.00	15.00	100.00
210302	Түлш, халаалт	28,330,700.00	28,206,226.00	124,474.00	99.56
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	48,134,500.00	48,133,110.00	1,390.00	100.00
210401	Бичиг хэрэг	4,731,700.00	4,731,400.00	300.00	99.99
210402	Тээвэр, шатахуун	37,740,900.00	37,739,810.00	1,090.00	100.00
210403	Шуудан, холбоо, интeрнeтгийн төлбөр	5,334,900.00	5,334,900.00	-	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	327,000.00	327,000.00	-	100.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	430,000.00	430,000.00	-	100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	430,000.00	430,000.00	-	100.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	16,885,000.00	16,885,000.00	-	100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	714,000.00	714,000.00	-	100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	71,000.00	71,000.00	-	100.00
210604	Урсгал засвар	16,100,000.00	16,100,000.00	-	100.00
<b>2107</b>	<b>Томилголт, зочны зардал</b>	9,037,000.00	7,764,000.00	1,273,000.00	85.91
210702	Дотоод албан томилголт	5,037,000.00	3,764,000.00	1,273,000.00	74.73
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	4,000,000.00	4,000,000.00	-	100.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр</b>	168,279,200.00	85,671,870.00	82,607,330.00	50.91
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээ	166,234,200.00	83,992,370.00	82,241,830.00	50.53
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	365,500.00	-	365,500.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	180,600.00	180,600.00	-	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	399,800.00	399,800.00	-	100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	85,000.00	85,000.00	-	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	838,000.00	838,000.00	-	100.00
210807	Газрын төлбөр	131,000.00	131,000.00	-	100.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	45,100.00	45,100.00	-	100.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	25,114,000.00	25,029,520.00	84,480.00	99.66
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	22,700,000.00	22,615,520.00	84,480.00	99.63
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,414,000.00	2,414,000.00	-	100.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	714,000.00	700,000.00	14,000.00	98.04
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	714,000.00	700,000.00	14,000.00	98.04
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	714,000.00	700,000.00	14,000.00	98.04
<b>13</b>	<b>ЗАРДЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	846,277,200.00	762,172,511.00	84,104,689.00	90.06
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	846,277,200.00	762,172,511.00	84,104,689.00	90.06
132001	Орон нутгийн төсвөөс	846,277,200.00	762,172,511.00	84,104,689.00	90.06
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1	1	-	
610001	Төсвийн байгууллага	1	1	-	
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	31	33	(2.00)	
620001	Удирдах ажилтан	14	13	1.00	
620002	Гүйцэтгэх ажилтан	9	9	-	
620003	Үйлчлэх ажилтан	3	3	-	
620004	Гэрээт ажилтан	5	8	(3.00)	
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>31</b>	<b>33</b>	<b>(2.00)</b>	
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	10	9	1.00	
650010	Гэрээт ажилтан	5	8	(3.00)	
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	13	13	-	

Улаанхус сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>25,660,600.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>25,660,600.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	25,660,600.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,024,000.00
210104	Урамшуулал	1,024,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	865,000.00
210402	Тээвэр, шатахуун	850,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	15,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	530,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	530,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,259,040.00
210702	Дотоод албан томилолт	1,259,040.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	21,982,560.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,982,560.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>25,965,365.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>25,965,365.00</b>
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	25,965,365.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

**Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар:**

Улаанхус сумын Засаг даргын Тамгын газрын зорилго нь төрийн бодлого боловсруулах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, мэдлэг чадвар бүхий боловсон хүчнээр эгнээгээ бэхжүүлж, төрийн ёс зүйг чандлан сахиж, нутгийн иргэдийн эрх ашгийг дээдлэн, төрийн үйлчилгээг нээлттэй, шуурхай хүргэхэд оршино.

Дээрх зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна.

- Алсын хараа, хэтийн зорилгын хүрээнд орон нутгаа хөгжүүлэх,
- Шинжлэх ухааны үндэслэлтэй төлөвлөлт хийж, орон нутгийн нөөц, иргэдийн санаачилгад тулгуурлан хөгжүүлэх,
- Орон нутгийн иргэдийн сумаа хөгжүүлэх гэсэн хүсэл эрмэлзэл, төрийн албан хаагчдын үйлчилгээгээ нээлттэй ил тод, хөнгөн шуурхай хүргэх,
- Ая тухтай хүний аюулгүй байдлыг цогцлон бүрдүүлэх

Улаанхус сумын Засаг даргын Тамгын газрын чиг үүрэг нь Монгол Улсын Үндсэн хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Төрийн албаны тухай хууль болон бусад эрх зүйн актуудыг удирдлага болон хэтийн төлөвлөгөөний биелэлтийг

Улаанхус сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

хянах, байгууллага, иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг тасралтгүй хангаж ажиллах чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллахад оршино.

### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

#### ***Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар***

Улаанхус сумын Засаг даргын Тамгын газар нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэр, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Татварын багц хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн болон олон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон олон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзэв.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сангийн сайдын 2023 оны 65 дугаар “Хөтөлбөр батлах тухай” тушаалаар аккрузл суурьт УСНББОУС-ыг нэвтрүүлэх дунд хугацааны хөтөлбөрийг баталсан байна.

Улаанхус сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

#### ***Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар***

Тус газар нь сумын Тамгын газрын даргын 2019 оны А/02 тоот тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг шинэчлэн батлах тухай журмыг мөрдлөг болгон ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Улаанхус сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Улаанхус сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 429.5 сая төгрөгөөр буюу 5.7 хувиар өссөн байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	1,500.0	1,291.6	(208.4)
Урьдчилгаа			
Бараа материал	22,063.0	22,043.0	(20.0)
Үндсэн хөрөнгө	9,191,254.5	9,686,623.3	495,368.7
<b>Нийт хөрөнгө</b>	<b>9,214,817.5</b>	<b>9,709,957.8</b>	<b>495,140.3</b>
Өр төлбөр	10,381.4	0	(10,381.4)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	9,204,436.2	9,709,957.8	505,521.7
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>9,214,817.5</b>	<b>9,709,957.8</b>	<b>495,140.3</b>

Дансны авлага 0.2 сая төгрөгөөр буурсан нь нийгмийн даатгалын шимтгэлийн авлагатай холбоотой байна.

Бараа материалын данс 0.02 сая төгрөгөөр буурсан нь аж ахуйн материалын дансны өөрчлөлттэй холбоотой.

Үндсэн хөрөнгийн данс 495.4 сая төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр худалдан авсан 20.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 994.6 сая төгрөгийн Хөх хөтөл багийн гүүр, 33.7 сая төгрөгийн инженерийн хийцтэй худаг, сумын ОНХС-аас хэрэгжсэн 100.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, БОАЖЯ-наас нийлүүлсэн 13.5 сая төгрөгийн ухаалаг дэлгэц /ком/, үнэ төлбөргүй авсан санхүүгийн программаар нэмэгдэж, аймгийн ИТХ-ын 2023 оны 113 тогтоолоор 99.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг худалдсан, 2023 оны 149 тогтоолоор 48.9 сая төгрөгийн хөрөнгийг балансаас баланст шилжүүлсэн, мөн тайлант оны элэгдлийн зардалтай холбоотой байна.

Тайлант оны үр дүнгээр Засгийн газрын хувь оролцоо данс 505.5 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 649.5 сая төгрөг, нийт зарлагыг 649.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

БӨА-2024/154/НА-СТА-ТШЗ

Улаанхус сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Төсвийн төслийн саналаас 37.1 сая төгрөгөөр бууруулж, 612.4 сая төгрөгөөр баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 3 удаа төсвийн тодотгол хийгдэж нийт дүнгээр 233.9 сая төгрөгөөр нэмэгдүүлж 846.3 төгрөгөөр баталсан байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 846.3 сая төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлэхээр баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 762,267.0 сая төгрөгийн санхүүжилт олгож, 0.09 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардалд 164.6 сая төгрөг баталсан боловч орлого биелэгдээгүйгээс 50 хувьтай хэрэгжсэн, мөн түүнчлэн үндсэн болон туслах үйл ажиллагааны зардлаас 1.7 сая төгрөгөөр дутуу олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 762.2 сая төгрөг буюу 90.1 хувьтай байгаа нь дээрх зардлуудтай холбоотой байна.

#### Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
70106	ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага	846,277.2	762,172.5	84,104.8	90.1
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	465,845.6	464,692.5	1,153.1	99.8
80102	Туслах үйл ажиллагааны зардал	195,100.3	194,489.0	611.3	99.7
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж	714.0	700.0	14.0	98.0
81102	Орон нутгийн нөөц хөрөнгө	20,000.0	19,915.5	84.5	99.6
81701	Байгаль орчныг хамгаалах	164,617.3	82,375.4	82,241.9	50.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Улаанхус сумын Засаг даргын Тамгын газрын нэмэлт дансанд өмнөх онд тараасан өвс, тэжээлийн үнээс 19.3 сая, аймгийн Засаг даргын дэмжлэгээр 1.0 сая, Статистикийн хэлтсээс 5.6 сая төгрөгийн орлого орж, аймгийн Санхүү, төрийн сангаас нээсэн эрхийн дагуу зарцуулж, жилийн эцэст 0.3 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Улаанхус сумын Засаг даргын Тамгын газар 2023 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Улаанхус сумын Засаг даргын Тамгын газар нь 2023 онд батлагдсан төсвийн хүрээнд 59.0 сая төгрөгийн бараа материал, 20.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу аймгийн Улаанхус сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор У.Ербол гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Улаанхус сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн 03/10 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Улаанхус сумын Засаг даргын Тамгын газрын төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1.5 хувиар тогтоосон суурь үзүүлэлтээр тооцож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 75 хувиар буюу 7,723.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж тайлант оны нийт зардлын дүн их хэмжээгээр өөрчлөгдсөн тул шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 75 хувиар буюу 12,060.0 мянган төгрөгөөр тогтоов.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус газар нь батлагдсан төсөвт багтаан үйл ажиллагаагаа явуулж, жилийн эцэст өр, авлагагүй ажилласан байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад “Төрийн хэмнэлтийн тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангаж ажилласан ба алдаа, зөрчил илрээгүй.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллээс цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээнээс 647.2 төгрөгийн 49 мэдээлэл, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээнээс 114.2 төгрөгийн 11 мэдээллийг оруулахаас, мэдээлбэл зохих бүх мэдээллийг цаг тухайд нь бүрэн мэдээлж ажилласан байна. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 100 хувьтай байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитаар алдаа, зөрчил илрээгүй тул нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд алдаа, зөрчилтэй асуудал гараагүй болно.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Улаанхус сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайланд завсрын аудитын хийгдэж, аудитаар илэрсэн зөрчлийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянаж үр дүнг аудитын тайланд тусгав.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж олгосон 116.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийсэн 8,265.5 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага өгөгдсөнөөс биелэлтийг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	116.0	1	116.0	100%
Албан шаардлага	1	8,265.5	1	8,265.5	100%
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>8,381.5</b>	<b>2</b>	<b>8,381.5</b>	

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Улаанхус сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан төсвийн зарцуулалтыг түүвэрлэн шалгасан тул, цалингийн зардлыг гүйцэтгэлийн шалгалтаар шалгах шаардлагатай.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

---

Аудитаар залруулга хийгдээгүй.

Аудитаар нийт 49,551.8 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс, 449.1 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 23,000.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 26,102.7 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

### 5.1 Төлбөрийн акт

Аудитаар нийт 449.1 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоов.Үүнд:

1.Засаг даргын Тамгын газрын хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн 5 дугаар сард 14 хоног ажилласан боловч цалинг 1,147.2 мянган төгрөгөөр тооцож бүрэн олгосон бөгөөд бодогдсон цалингаас 449.1 мянган төгрөгийг илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсгийн 41.2.3-т “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, Нягтлан бодлох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 -д “Үнэн зөв байх”, 13 дугаар зүйлийн 13.1-т “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.5-т “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно...” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү бодож олгосон 449.1 мянган төгрөгийн цалинг нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

### 5.2 Албан шаардлага

Аудитаар нийт 23,000.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага өгөв.

1.Төсвийн хөрөнгөөр “Хүрэн уул хайрхан”, “Архар угалзат” нөхөрлөл, “Хөх тэнгэрийн эсгий туургатан” ТББ-д аргалд өвс тэжээл тавих, контент бүтээх арга хэмжээнд 9,000.0 мянган төгрөгийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа гэрээ байгуулаагүй, хийсэн ажлыг дүгнээгүй байхад шилжүүлсэн, Агнуур судлалын нийгэмлэгт аргал тоолох арга хэмжээнд 14,000.0 мянган төгрөгийг бүрдэл дутуу баримтаар шилжүүлсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.2 -т “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих, Нягтлан бодлох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 -д “Үнэн зөв байх”, 13 дугаар зүйлийн 13.1-т “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.4-т “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон

---

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.  
БӨА-2024/154/НА-СТА-ТШЗ

Улаанхус сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

цахимаар бичилт хийж баталгаажуулна”, 13.5-т “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно...”, 13.7-т “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлэв.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Зардлын данстай холбоотой асуудал

##### 1.1 Илрүүлэлт:

Төрийн захиргааны албан тушаал эрхэлдэг албан хаагчдад 30 хувиар тооцож, нийт 26,102.7 мянган төгрөгийн орон нутгийн нэмэгдлийг тушаал, шийдвэргүй олгосон нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэр, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5-т “Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргын тамгын газрын дарга, Засаг даргын дэргэдэх газар, хэлтэс, албаны дарга эрх хэмжээнийхээ хүрээнд тушаал гаргаж, тогтоосон журмаар үйлдсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Төрийн захиргааны албан тушаал эрхэлдэг албан хаагчдад орон нутгийн нэмэгдлийг тушаал, шийдвэрийн дагуу олгож хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруул аагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Дүн</b>												

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	Үүнээс				
		Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж	Хариуцлага тооцуулах	Хууль, хяналтын

Улаанхус сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

									албан шаардлага		байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Илүү цалин олгосон	1	449.1	1	449.1								
Бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийсэн	1	23,000.0			1	23,000.0						
Орон нутгийн нэмэгдлийг тушаал, шийдвэргүй олгосон	1	26,102.7					1	26,102.7				
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>49,551.8</b>	<b>1</b>	<b>449.1</b>	<b>1</b>	<b>23,000.0</b>	<b>1</b>	<b>26,102.7</b>				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								